



## ЗӨВЛӨМЖ

## #1. ЗӨВЛӨМЖ

**Авлигатай тэмцэх газрын 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 1/3753 дугаар албан бичгээр хүргүүлсэн зөвлөмжид дурдсан зөрчил, дутагдал дахин илэрч байгаад дүгнэлт хийх, зөвлөмжийг нэгмөр хэрэгжүүлж ажиллах.**

**Нэг.** Сангийн сайдын 2012 оны 239 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.3-т заасан "энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж **нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана**", 3.1-т заасан "Засаг даргын нөөц хөрөнгийг **Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн** тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна." гэсэн заалтыг тус тус хэрэгжихгүй байна. Тухайлбал, Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалттай танилцахад сайд, дарга, яам, агентлагийн ажлын хэсэг, зочид, төлөөлөгчдийг хүлээн авах, хүндэтгэл үзүүлэх, иргэд, төрийн албан хаагчдад дэмжлэг үзүүлэх, сумдын ой, баяр наадамд хандив өгөх зэрэгт Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулсан байна. Дорнод аймгийн Засаг дарга нь Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг зарцуулахдаа Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын тухай журам"-ын 2.3-ын "Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх" гэж заасныг үндэслэн төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. 2018 онд Засаг даргын нөөц хөрөнгө 255 000 000 төгрөг батлагдсанаас 10 дугаар сарын 15-ны байдлаар 43,1 хувь буюу 109 929 600 төгрөгийн гүйцэтгэл гарч дээрх журмын 2.1.3-т заасан арга хэмжээнд 53 305 900 төгрөгийг дэмжлэг, хүндэтгэл үзүүлэхэд зарцуулсан байна.

**Хоёр.** Орон нутгийн үйл ажиллагааг зохицуулах шаардлагатай нийтийг хамарсан тогтоол, шийдвэр, дүрэм, журам, эрх зүйн актыг хууль тогтоомжид нийцүүлэн гаргадагүй, өөрийн эрх хэмжээг хэтрүүлсэн шийдвэр гаргаж буй явдал таслан зогсоох. Тухайлбал, Дорнод аймгийн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012.12.09-ны өдрийн 69 дугаар "Журам батлах тухай" тогтоолоор батлагдсан байна. Журмын 4.1-д сар бүр 45.000 төгрөгийг Тэргүүлэгчид олгох гэж заасан байна. Уг тогтоолд 2014.02.21-ны өдрийн 18 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж сар бүр 100,000 төгрөг олгохоор заасан байна. Тогтоолын үндэслэх хэсэгт хуулийн заалтыг тодорхой тусгаж өгөөгүй, Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д заасан "хуульд үндэслэх" зарчмыг баримтлаагүй, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14.2-т заасны дагуу ИТХ-аар шийдвэр гаргаагүй байна. (Хавсралт 1)



## #2. ЗӨВЛӨМЖ

Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт, санхүүжилтийн байдалтай танилцахад 2018 онд Үндэсний баяр наадмын зардалд аймаг 120,000.000, Хэрлэн сум 10,000.000, Матад сум 12,857.600, Халхгол сум 6,000.000 төгрөгийг баталж зарцуулжээ. Энэ нь Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолоор “Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоосон”-ыг зөрчсөн байна.

Харин Эрүүгийн хуулийн /Шинэчилсэн найруулга/ 22 дугаар зүйлийн 22.8-д “Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах” гэх зохицуулалт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулж мөрдөгдөж эхлэсэн ба төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу, үр ашигтай захиран зарцуулахад цаашид онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна.

***Төсвийн хөрөнгийг хууль тогтоомжид заасан хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэхгүй байх.***

## #3. ЗӨВЛӨМЖ

Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй, хуульд заасан хариуцлагыг удирдлагын зүгээс тооцоогүй, өргөдөл гомдлыг дарагдуулах, гээгдүүлэх зэрэг зөрчил түгээмэл байна. Тухайлбал, Улсын бүртгэлийн хэлтсийн Улсын бүртгэгч “Э” нь иргэний хил нэвтрэх үнэмлэхийг алдаатай бичиж, тухайн иргэнээс хилээс буцах зардлыг нэхэмжилсэн талаарх гомдол удаа дараа ирсэн боловч мөн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй байна.

Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн шүдний тасгийн эмч, сувилагч нар 2018 оны 8 сард иргэнээс хууль бус төлбөр авсан гэх гомдлыг хугацаа хожимдуулж шийдвэрлэсэн г.м зөрчлүүд түгээмэл байна.

***Сахилга, ёс зүйн зөрчил болон өргөдөл, гомдолд дүн шинжилгээ тогтмол хийх, зөрчил дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, ил тод байдлыг хангаж, хүнд сурталтай төрийн үйлчилгээ, албан хаагчийн талаарх дүн мэдээг нийтэд мэдээллэх***



## #4. ЗӨВЛӨМЖ

**Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг чангатгах, хугацаа хэтэрсэн зээлийг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх, тус сангийн дансанд бусад эх үүсвэр бүхий хөрөнгийг байршуулахгүй байх, албан хаагчийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах.**

Дорнод аймгийн хувьд Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, сангийн хөрөнгийн захиран зарцуулалт хангалтгүй, зээлийн 30-40 хувь нь чанаргүй, эргэн төлөгдөөгүй байна. Тухайлбал,

1/ Баян-Уул сум 2011 оноос хойш 53 иргэнд 397,100,000 сая төгрөгийн зээл олгосноос эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн 22 зээлдэгчийн 146,151,828 төгрөгтэй тэнцэх зээл байна.

2/ Матад сум 2011 оноос хойш 61 иргэнд 313,200,000 сая төгрөгийн зээл олгосноос эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн 26 зээлдэгчийн 101,474,240 төгрөгтэй тэнцэх зээл байна.

3/ Цагаан-Овоо сум 2011 оноос хойш 94 иргэнд 384,500,000 сая төгрөгийн зээл олгосноос эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн 40 зээлдэгчийн 130,636,391 төгрөгтэй тэнцэх зээл байна.

4/ Халх гол сум 2011 оноос хойш 86 иргэнд 569,560,000 сая төгрөгийн зээл олгосноос эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн 22 зээлдэгчийн 71,782,725 төгрөгтэй тэнцэх зээл байна.

Баян-Уул сум 2018 оноос Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хяналт, үр дүнг сайжруулах ажил зохион байгуулж, хяналтын хуудас гарган, зээлийн хяналтыг сайжруулах чиглэлийн ажлыг эхлүүлсэн байсан ба уг туршлагыг бусад сумдад нэвтрүүлэх, илүү үр дүнтэй бусад ажлыг зохион байгуулахад анхаарах нь зүйтэй байна.

*/Сум хөгжүүлэх сангийн схемийг 4 дугаар хавсралтаар/*

**#5. ЗӨВЛӨМЖ**

**Хяналт шалгалтын давхардал, хүнд суртал, чирэгдэл үүсгэж буй хүчин зүйлсийг арилгахад анхаарах, төрийн байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчид томилолтын зардлыг бусдаар даалгах зэрэг аливаа санхүүгийн дэмжлэг авахгүй байх.**

Хяналт шалгалтын байгууллагууд давхардсан байдлаар суманд очиж шалгалт хийж байна. Суманд жилд дунджаар 13-15 байгууллагын 80-120 хүн давхардсан байдлаар албан томилолтоор ирдэг ба чиг үүргийн хувьд давхардсан тохиолдлууд байна.

Тухайлбал, Санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аймгийн Аудитын газар, Санхүүгийн хяналт, аудитын алба зэрэг байгууллагууд ойрхон нэг чиглэлийн шалгалт явуулж байгаа нь суманд чирэгдэл, ажлын ачаалал үүсгэх зэрэг сөрөг үр дагавартай байна.

**#6. ЗӨВЛӨМЖ**

**Худалдан авах ажиллагааны төлөвлөлт үр дүнг сайжруулах, зураг, төсөв хийгдээгүй төсөл арга хэмжээг баталж санхүүжүүлэхгүй байх.**

Дорнод аймгийн хэмжээнд 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 18 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсанаас зураг төсөв шаардлагатай 13 төсөл арга хэмжээний зураг, төсөв нь төсөв батлагдсанаас хойш буюу тайлант хугацаанд хийгдсэн байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 32 төсөл арга хэмжээний төлөвлөгдсөнөөс зураг, төсөв шаардлагатай 2 төсөл арга хэмжээний зураг, төсөв мөн л төсөв батлагдсанаас хойш хийгдсэн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд 588,400.000, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 311,700.000 төгрөгийн ажлыг зураг төсөв хийгдээгүй байхад батлан хэрэгжүүлсэн байна.

Төсөл, арга хэмжээний мөнгөн дүнд өөрчлөлт орж батлах, төлөвлөлт хангалтгүй хийгдсэнээс болж зураг, төсвийг дахин хийлгэх тохиолдлууд гарсан байна. Цаашид хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад нэр, байршил тодорхой, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулагдсан, магадлал хийгдсэн, зохих зөвшөөрлүүд олгогдсон төсөл арга хэмжээнүүдийг Төсвийн тухай хууль болон Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын дагуу ажиллах нь зүйтэй байна.



Он дамнасан дуусаагүй барилга бүтээн байгуулалтын ажил олон байна. Үүнийг Засаг дарга болон удирдлагын зүгээс шийдвэрлэх, орон нутгийн өмчит зарим аж ахуй нэгжүүд ашиггүй ажилдаг, төсөвт хүндрэлтэй байгаа асуудлуудыг шийдвэрлэх талаас анхаарч ажиллах шаардлагатай байна. Тухайн орон нутгийн өмчийн төлөөлөн удирдах зөвлөл болон аймгийн орон нутгийн удирдлагаас компанийг үр ашигтай ажиллуулах, компанийн удирдах ажилтнууд хөрөнгө завших, үргүй зардал гарахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай. Тухайлбал, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Дорнод аймгийн аялал жуучлалын мастер төлөвлөгөө боловсруулах ажил г.м.

Гүйцэтгэгч талын баримтын дутуу бүрдүүлэлт, зөрүүтэй мэдээлэл, захиалагч талын хяналтгүй байдлуудаас үүдэн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа компанийн ажиллах хүчний чадавх, техник, тоног төхөөрөмжийг бүрэн гүйцэд үнэлэлгүй шалгаруулж, ажлын явцад хяналт бүрэн тавихгүй байгаа нь чанаргүй ажил хийгдэх, үргүй зардал гарах нөхцөлийг бий болгож байна.

Мөн төсөвт байгууллага болон сумдаас ирүүлсэн улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний саналыг эрэмбэлэхдээ, хурлаар хэлэлцэж ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон эсэх нь баримтаар нотлогдохгүй байгаа бөгөөд төлөвлөлтийн талаар судалгаа шинжилгээ хийсэн баримт материал байхгүй байна. Тухайлбал, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд 320.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Зүүн бүсийн ахмад настны асрамжийн төвийг байгуулсан байна. Барилгын хувьд туршлагатай компани чанартай, сайн гүйцэтгэсэн боловч төвийн инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй учраас ашиглалтгүй байна.

## #5. ЗӨВЛӨМЖ

**Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлд анхаарч, төсвийн үр ашигтай хэмнэлттэй байх зарчмыг баримтлах**



## #6. ЗӨВЛӨМЖ

**Тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангах, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр тендерт оролцогч компанийн ажиллах хүч, техник хэрэгслээр бүрэн хангагдсан байдал, ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах.**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд нийт 19 төсөл, арга хэмжээ (шилжих 1, шинээр 18) хэрэгжсэнээс ажиллах хүчин, техник, тоног төхөөрөмж шаардагдах 14, шаардлагагүй 5 төсөл, арга хэмжээ байна. Эдгээр 14 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчдээс ажиллах хүч, техник хэрэгслээр бүрэн хангагдсан 11, бүрэн хангагдаагүй 3 компани байсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 12 дугаар зүйлд заасан шаардлагад нийцэхгүй байна. Тухайлбал, Ажиллах хүч, техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй:

- Барилгын цахилгаан, сантехникийн засвар /Хэрлэн сум, БТСГ/-ыг гүйцэтгэсэн “Дорнын гэрэлт цамхаг” ХХК – *НДШ төлдөг 1 ажилтан, 29,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байгаа нь ажиллах хүч, техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй.*
- Сургуулийн барилгын гадна дулааны шугам засвар /Хэрлэн сум, 11-р сургууль/-ыг гүйцэтгэсэн “Дорсүхэ” ХХК – *17 ажилтантай гэх боловч НДШ төлдөг 2 ажилтан, санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө тусгагдаагүй.*
- Сургуулийн барилгын халаалтын тогооны засвар /Халхгол сум, Ялалт баг/-ыг гүйцэтгэсэн “Бүжнар” ХХК - *Татвар төлдөг 13 ажилтан, 137,5 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй гэх боловч энэ ажлыг гүйцэтгэхдээ компанийн бус гадны гэрээт ажилтнуудаар гүйцэтгүүлсэн.*

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд нийт 39 төсөл, арга хэмжээ (шинээр хэрэгжүүлэх 28, шилжих 7, авто замын сангаар 4) хэрэгжсэнээс ажиллах хүч, техник, тоног төхөөрөмж шаардагдах 22 (барилгын засвар, халаалтын тогоо, шугамын засварын ажилд), шаардлагагүй 17 төсөл, арга хэмжээ байна. Эдгээр 22 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчдээс ажиллах хүч, техник хэрэгслээр бүрэн хангагдсан 17 компани, ажиллах хүчээр бүрэн хангагдаагүй 5 компани байна. Тухайлбал, Ажиллах хүчин, техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй:

- Сургуулийн барилгын гадна дулааны шугам засвар /Хэрлэн сум, 11-р сургууль/-ыг гүйцэтгэсэн “ДОРСҮХЭ” ХХК – *НДШ төлдөг 2 ажилтантай, компанид бүртгэлтэй үндсэн хөрөнгөөгүй,*
- Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинээр баригдах хатуу хучилттай авто замын трассыг сэргээн тодотгох, тэмдэгжүүлэх ажлыг гүйцэтгэсэн “Дорнын Транзит” ХХК – *НДШ төлдөггүй, орон нутагт бүртгэлгүй,*
- Аймгийн залуучуудын нэгдсэн мэдээллийн сайт хийх /ГБХЗХГазар/ ажлыг гүйцэтгэсэн “Дорнын хийц пресс” ХХК – *НДШ төлдөггүй, орон нутагт бүртгэлгүй,*
- Төрийн байгууллагуудын вэб сайтад тавих шаардлага MNS 2011 стандартыг хангасан аймаг, сумдын нэгдсэн цахим хуудас хийх ажлыг гүйцэтгэсэн “Мэдээлэл технологийн чадамжийг дээшлүүлэх төв”, “БААМБАЛБИ” ХХК - *Орон нутагт бүртгэлгүй, НДШ төлдөггүй,*
- Сүмдад инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах /Баяндун, Баян-Уул, Хөлөнбуйр, Гурванзагал сум/ ажлыг гүйцэтгэсэн “Сатабу” ХХК - *НДШ төлдөг 2 ажилтан, 143,9 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй байгаа нь ажиллах хүч, техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй гэж үзэх үндэслэл болсон.*



## #7. ЗӨВЛӨМЖ

Дорнод аймгийн хэмжээнд 7 төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагаатай танилцахад дийлэнх нь ОНӨААТҮГ статустай боловч өөрийгөө санхүүжүүлэх чадваргүй байгаа нь “Төрийн болон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д зааснаар “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ” гэсэнтэй нийцэхгүй байна.

**Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн чадамжийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогын ажил хийх.**

## #8. ЗӨВЛӨМЖ

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үйл ажиллагаатай танилцахад Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар 2017 онд хэрэгжүүлсэн 33 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр 871 сая төгрөг батлагдаж, үлдэгдэл 62,321,245 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар 2018 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн явцтай танилцахад дараах зөрчил дутагдлууд гарч байна. Тухайлбал,

1. Хэрлэн голын эргийн дагуу тохижилт, хамгаалалтын ажил хийх /зураг төсвийн хамт/ Нийт төсөв 208,000.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий тендерт Ган-октеадр ХХК шалгарсан ч гүйцэтгэл байхгүй байна.

2. Байгалийн баялгийн зүй бус ашиглалтыг хянах, хяналт шалгалтын орчин үеийн багаж төхөөрөмж, камерыг Хэрлэн гол дээрх Баянтүмэн, модон, Ялалтын гүүрэн дээр суурилуулах ажлын зардал 150 сая төгрөгийг ИТХ-аар батлуулж бараа материал нийлүүлэх тендер болгон зарлахад “Дорнын арвижих” ХХК шалгарч 147,977,198 мянган төгрөгний нийт 58 төрлийн барааг “Гэрэл, сэтгэмж” Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт 2017 оны 10 дугаар сарын 06-ны өдөр хүлээлгэн өгсөн байх боловч 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар гүүрнүүдэд хяналтын камер суурилагдаагүй байна.

**Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд хяналт тавих, гүйцэтгэл, ажлын үр дүнг сайжруулах.**

**#9. ЗӨВЛӨМЖ**

***Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг үр дүнтэй ажлуудад зарцуулах.***

Иргэдийн Төлөөлөгчдийн хурал Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төсвийг сум орон нутагт явах томилолтын зардал голчлон зарцуулж байна. Сангийн хөрөнгийг Хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 1998 оны 88/152 дугаар тушаалаар батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-д заасны дагуу хууль сахиулах, нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагуудаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар иргэд, байгууллагын дунд зохиох эрх зүйн сургалт, сурталчилгаа, хэв журмын урамшилтай эргүүл, жижүүр томилох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой ажил зохиож үр дүнд хүрсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах зэрэг ажлуудад голчлон зарцуулах нь зүйтэй байна.

**#10. ЗӨВЛӨМЖ**

***Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр салбарын яам, агентлагтай хамтран ажиллаж үр дүнд хүрэх.***

Дорнод аймгийн хувьд Дашбалбар сумаас бусад сумын эмийн эргэлтийн сан алдагдалтай ажиллаж байна. Аймгийн Эрүүл мэндийн газар эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр анхаарч ажиллаж байгаа нь сайшаалтай боловч аймгийн удирдлагын зүгээс дэмжлэг үзүүлж анхаарч ажиллах нь зүйтэй. Салбарын яам, агентлагтай үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр бодлогын баримт бичиг боловсруулж, үр дүнг дүгнэж ажиллах нь зүйтэй байна.





Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас хэрэгжүүлж буй 10 багц, 68 ажил үйлчилгээтэй танилцсан ба үүнээс Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт явцтай нарийвчлан танилцахад дараах зөрчлүүд байна. Тухайлбал, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2018 онд хөдөлмөр эрхлэх чиглэлээр суралцсан 12 төгсөгчид олгох 11 төсөлд 33 сая төгрөгийн зээл олгосон байх боловч зээл олгох хурал хэдэн онд, хэзээ болсон нь тодорхойгүй тэмдэглэл хөтөлсөн, төсөл нэр бүрийг хурлаар хэлэлцээгүй, сонгон шалгаруулах хуралд оролцсон тус газрын 4 мэргэжилтэн хурлын тэмдэглэлд гарын үсэг зурж баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд гаргасан байгаа нь төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаггүй болохыг харуулж байна.

### #11. ЗӨВЛӨМЖ

**Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт хяналт тавих, сонгон шалгаруулалтыг хуульд заасан хүрээнд зохион байгуулж, олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх.**

Аймгийн нийгмийн Даатгалын хэлтэс иргэд, даатгуулагчдад үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай хүргэх зорилгоор зохион байгуулалтын өөрчлөлтийг хийснээр тэтгэвэр тогтоох, олгох үйл ажиллагаа өргөдөл хүлээн авснаас хойш 1 сарын дотор шийдвэрлэгддэг байсан бол ажлын 7 хоногт шийдвэрлэгддэг болсон байна. Мөн ажлын зохион байгуулалтаа өөрчлөн үдийн цайны завсарлагагүй үйлчилгээ үзүүлж, “Нийгмийн даатгал” гар утасны апплейкшн Дорнод аймгийн төрийн албан хаагч, ард иргэдэд нэвтрүүлсэн байгаа нь сайшаалтай байна.

### #12. ЗӨВЛӨМЖ

**Авлига гарах нөхцөл боломжийг бууруулах чиглэлээр мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, салбарын үйл ажиллагааг иргэдэд үр дүнтэй хүргэх чиглэлээр улам бататган, төрийн бусад байгууллагуудад нэвтрүүлэх.**



## #13. ЗӨВЛӨМЖ

**Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүйгээр томилох, томилсны дараа хянуулах зөрчлийг таслан зогсоох.**

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, 23.6 дахь хэсэгт заасны дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтан нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэхийг хянуулсны дараа тухайн албан тушаалд томилох үүрэгтэй боловч салбарын хэмжээнд нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулалгүйгээр томилох, томилсны дараа хянуулдаг зөрчил давтагдаж байна. Тухайлбал, Дорнод аймгийн шалгалтанд хамрагдсан байгууллагуудын хэмжээнд 5 албан тушаалтныг ХАСУМ хянуулалгүйгээр, 1 албан тушаалтан томилсны дараа хянуулсан байна. (Хавсралт 2)

## #14. ЗӨВЛӨМЖ

**Албан тушаалтан томилогдсоноос хойш хууль заасан хугацаанд хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах, хугацаандаа гаргаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох арга хэмжээ авч, түүнд тавих хяналтыг сайжруулах, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарах.**

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасны дагуу мэдүүлэг гаргагч албан тушаалтан хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргах үүрэгтэй.

Гэтэл Дорнод аймгийн шалгалтанд хамрагдсан байгууллагуудын хэмжээнд 20 албан тушаалтан хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг мэдүүлээгүй буюу хугацаа хожимдуулж мэдүүлсэн байна. (Хавсралт 3)



Захиргааны ерөнхий хуулийн шаардлагад нийцүүлэн “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг шинэчлэн боловсруулж, Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан бөгөөд уг журам нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4036 дугаартай бүртгэгдсэн (журмыг

<https://www.legalinfo.mn/law/details/13778?lawid=13778> -ээс татаж үзэх). Журмын 4.1-т “Албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэсэн болон нийтэд мэдээлсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор журмын 2.1, 3.1-т заасан мэдээллийг тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэр (хуулбар)-ын хамт эсхүл холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.” гэж заасныг мөрдөж ажиллах шаардлагатай.

## #12. ЗӨВЛӨМЖ

**Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлэх, заасан хугацаанд холбогдох мэдээллийг ирүүлж хэвших.**